

Тахийн хатуу ширүүн замналын түүх

(*Equus ferus ssp przewalskii*)

1878 он



Оросын судлаач Николай Михайлович Пржевальский үл мэдэгдэх зэрлэг адууны арьс, гавлын ясыг Европд, буюу Санкт-Петербург хотод авчирсан байна . Тухайн үед тарпан устаж үгүй болсны дараагаар зэрлэг адууг Европд мөхсөн гэж дүгнэж байжээ

1899-1901 он



Hagenbeck болон Falz Fein нар байгалиас нийтдээ 52 тахийн унагыг "амжилттай барих ажиллагаа" явуулж Европд авчирсан байна.

1947

Хамгийн сүүлд байгалиас барьсан тахь: Орлица III гэх гүүг Аскания-Нова байгалийн нөөц газар (Украин)–д хүргэжээ. Энэ гүү нь амьтны хүрээлэнд байгаа тахийн удмыг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг байна.

1940-өөд оноос

Зэрлэг адууны өнөөгийн популяцийн үүсэл нь 13 үржлийн тахиас гаралтай юм.

1958 он

Амьтан судлаач Erna Mohr анхны удмын бичгийг хөтөлж эхэлсэн. Үүнд 1899-1958 оны хооронд амьтны хүрээлэнгүүдэд байсан 238 тахийн мэдээлэл бүртгэгдсэн.

1960-аад оны сүүлч

Праг болон Мюнхены амьтны хүрээлэнгүүд анхны удаа хоорондоо тахь солилцжээ

1960-аад он

Зэрлэг байгальд тахь нь Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн Гүн тамга гэх газарт сүүлчийн удаа үзэгдсэн мэдээ байдаг

1985 он

Өмнө нь Европын ховор зүйлүүдийг хамгаалах хөтөлбөр гэж нэрлэдэг байсан EAZA Ex-situ Program (EEP)-ын нь Европын амьтны хүрээлэн, аквариумын нийгэмлэгийн (EAZA) амьтдын популяцийн менежментийн хөтөлбөр юм. Энэ бол амьтны хүрээлэнгийн ховордсон амьтдыг үржүүлэх чиглэлээр бүс нутгийн хэмжээнд үржүүлдэг хөтөлбөрүүдийн нэг юм. Тахь нь энэхүү хөтөлбөрт орж 1990 оны эхэн хүрэхэд хүний асаргаанд байгаа тахийн тоо 1000 орчим болсон

1985 он

Олон улсын байгаль хамгаалах холбооноос (IUCN) Монгол улсад тахийг сэргээн нутагшуулах боломж бүхийг газруудын судалгаа хийсэн

1991 он

Christian Oswald-ын санхүүжилт, санаачлагаар Тахийн талд анхны хашаа барьж эхэлсэн

1992 он

Анхны тахийн тээвэрлэлтийг Аскания-Новагаас Тахийн талруу, Нидерландаас Хустайн нуруунд (Улаанбаатар хотын ойролцоо газарт) хийсэн

- 1997 он Тахийн талд анхны тахиудыг дасан зохицох хашаанаас онгон байгалд нь чөлөөлсөн
- 1992-2004 онуудад  Нийтдээ 89 тахийг Европоос Тахийн талд авчирсан байна
- 1999 он  **Олон улсын Тахь Групп (ITG)**
Анхны Ерөнхийлөгч Жан-Пьер Зийгфридийн удирдлага дор тахь сэргээн нутагшуулахад оролцогч байгууллагууд нэгдэн ажиллаж эхэлсэн
- 2006 он  ДЦГ-ын Хамгаалалтын захиргаа болон судалгааны дэд бүтцийг сайжруулах барилга байгууламж баригдав
- 2007 он Анх удаа Монголд дотооддоо тахь тээвэрлэх ажил хийсэн: Хустай нуруунаас гурван азарга Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт тээвэрлэгдэж ирэв
- 2010 он Зуд болж тахийн тоо толгой буурав: тахийн ердөө 1/3 хувь (ойролцоогоор 50 тахь) нь амьд үлдсэн
- 2012 он Хятадын хойд хэсэгт орших Жимсарын тахь үржүүлэх төвөөс дөрвөн азарга Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт тээвэрлэв
- 2012-2021 он Праг хотын амьтны хүрээлэн болон Чехийн агаарын нисэх хүчин жил бүр дөрвөн гүүг EAZA Ex-situ Program (EEP) -аар Тахийн талд генетикийн хэлбэлзлийн өндөр түвшнийг хангахын тулд тээвэрлэсэн
- 2017 он Монголд Тахийг сэргээн нутагшуулж буй төслүүд 25 жилийн ойгоо тэмдэглэв
- 2017 он. Тахийн талд, тахийн тоо толгой 200-д хүрэв
- 2020 он Тахийн амьдрах орчин болох Говийн их дархан цаазат газар “Б” хэсгийн талбай нь хоёр дахин нэмэгдэж 18'000 км²-д хүрэв
- 2020 он Анх удаа тахийн тоо толгой 300 давсан

Түүхэн баримтуудыг: Jiri Volf "Das Urwildpferd" ISBN 3 89432 471 6 ном болон Тахийн талд тахийн анхны тээвэрлүүлтийг харуулсан киног дараах линкээр үзэж болно:

<https://www.youtube.com/watch?v=4tMFyL5PRr0>